

## МОНГОЛ УЛСЫН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ВЕКТОР

Г. Сүхбаатар

Монгол улсын түүхийг дотоод (9, 10) гадаадын эрдэмтэд судалсан шинжилгээний сүүлийн үеийн үр дүнд тулгуурлан, систем аргын үндсэн дээр Монголын төр ёсны 2200 гаруй жилийн түүхэн хөгжлийн векторын талаар нэлээд тодорхой ярих боломжтой боллоо.

Аливаа улсын түүх бол тухайн үеийн тухайлсан тодорхой эрмэлзлэл, зорилготой амьд хүмүүсийн үйлчлэлцсэн, нөлөөлөлцсөн бодитой үйл ажиллагааны систем нийлбэр үр дүн мөн. Иймд тухайн үеийн нийгмийн анги, давхраа болох хүмүүсийн бодит үйл ажиллагаа нь вектор юм. Түүхэн хөгжилд эерэг, сөрөг, саармаг (тэг) вектор хэрэглэнэ. Хаан (удирдлага) тэргүүтэй төрийн засаг нь тухайн нийгмийг жолоодох хүчин байдаг учир төрийн засгийн хүчний параллелограмм нь нийгмийн хөгжлийг чиглүүлэх функцтэй байдаг.

Одоогийн Монгол улсын нутгаар төвлөн тогтсон Хүннү улс (МЭӨ 209—МЭ—93)-ын үндсэн хүн ам нь эртний монгол угсаатан мөн болохыг нийгэм байгалийн ухааны эрдэмтдийн сүүлийн үеийн судалгаа нотлов. Хүннү нар уугуул нутаг, малын үүлдэр, сүргийн бүрэлдэхүүн, нийгмийн байгуулал, эдийн ба утга соёлын угсаатны шинж заншил, зан үйлийн өвөрмөц онцлог, хүннү хэлний үгсийн үндсэн сангийн утга тодорхой зарим үгийн хэлний хамаадал (20), антропологийн төрх-генетикийн хувьд монгол угсаатан мөн нь бүрэн нотлогдов. Д. Түмэн Монгол улсын нутгаас олдсон антропологийн хэрэглэгдэхүүнийг олон жил судалснаа дүгнэн бичихдээ: «Үүнээс үзэхэд орчин үеийн монголчуудын антропологийн маяг бүрэлдэх процесс манай эриний эхээр өөрөөр хэлбэл хүннүгийн үед дууссан гэж дүгнэх бүрэн үндэстэй байна» гэжээ. (34-н-121). «Төв Монгол бол хүннүгийн шаньюй нарын уугуул нутаг мөн. Хүннү нарын газрын зургийг Монголын генийн газар зүйн зурагтай дүйлгэхэд орчин үеийн монголчуудын генийн сангийн цөмийг одоо бүрдүүлж байгаа генийн бөөмнөрөл хүннүгээс гаралтай байж болохыг бүрэн дүүрэн тодорхой гэрчлэн харуулж байна... Орчин үеийн монголчууд чухам генийн хувьд умард хүннү нараас гарвалын залгамж холбоостой болохоо илтгэн үзүүлж байна» гэж Ю. Г. Рычков, Ж. Батсуурь нар бичсэн (40-н 60) Ж. Батсуурь цаашдын судалгаандаа бичихдээ «Монголчуудын генийн сангийн голомт хүннү улсын нутаг дэвсгэр түүний улс төрийн төвтэй яв цав давхцаж байгаа явдал өнөөгийн монголчуудын генийн сангийн голомт ямар ч байсан Төв Азид хамгийн түрүүнд төр улсаа байгуулан гарч ирсэн хүннү нараас өвлөн ирсэн болохыг тодорхой харуулж байна» гэжээ. (5-н 85). Иймд хүннү нар казахстаны түүхийн турш дахь үндсэн хүн амтай антропологийн хувьд ч, генетикийн хувьд ч огт холбогдохгүй байгаа нь О. Исмагуловын судалгаанаас (36-н 50, 137, 140—141, 37-н 167—170) тодорхой байна.

Г. Сүхбаатар. — Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор.

Хүннү нар угсаатны өвөрмөц шинжээрээ эртний түрэгчүүдтэй огт холбогдолгүй байсан талаар хэдэн жишээ дурдая. Хүннү нар нас барагсдын цогцсыг авсанд хийж бунхантай бунхангүйгээр газар булж оршуулдаг нь сүмбэ, нирун, язгуур монголчуудынхтай адил юм. Орхоны түрэгчүүд нас барагсдын хүүрийг шатаан чандарлаж хавар, намар оршуулах ёслол үйлдэн, баатар эрсийн булшны дэргэд ихэвчлэн хүн чулуу-балбал тавьдаг. Хүннү, сүмбэ, язгуур монголчууд хаан өргөмжлөхдөө хааны ургийн 7 хүн хаанаа хар эсгий дээр суулган хаан ширээнд зална (215-н 33). Түрэгийн хаан угсааны том түшмэд хаан суух хүнээ хар эсгийн дээр суулган нар зөв 9 удаа тойруулаад морь унуулан хоолойгий нь ухаан алдтал нь боож, сулруулан сэргэмэгц нь хэдэн жил хаан суух вэ гэж асуугаад ширээнд зална. Хүннү, сүмбэ, табгач, язгуур монголчуудын хооронд табгачийн нүүдлийн тухай домог, монголчуудын Эргүнэ гүнгийн домгоор шууд залгамж холбоос байсан байна. (22-н 183—187, 25-н 28—30). Орхоны түрэгчүүд уг гарлаа зөвхөн VI зууны эхнээс буюу Буман, Истемн хаанаас эхэлдэг (35-н 36) учир Хүннүтэй ямар нэг залгамж холбоогүй байна. Хүннү нар гэндүү (эр) чоно тотемын тухай домгоороо өөрөөр хэлбэл уртын дуугаараа язгуур монголчуудтай шууд холбогдоно. (25-н 23—24). Дайснууд түрэгчүүдийг довтлон хядаад, ганц эрэгтэй хүүхдийг зэрэмдэглэн орхиход түүнийг гичий чоно тэжээн өсгөсөн байна. Чингээд тэр хүү том болоод гичий чонотой гэрлэхэд чононоос арван хүү төрсөн нь түрэгийн ашина овгийнхон болжээ. Иймд түрэгчүүд гичий чононоос гаралтайгаа дурсан чононы алтан толгойтой утуг барьж (25-н 56—57) явна. Мон чоно хөхөж байгаа хүүхдийг дүрслэн хийсэн чулуун хөшөө Архангай аймгийн Бугат сумын нутгаас олдсон, одоо Цэцэрлэг хотын музейд бий. Түрэгийн энэ домог Хүннүгийн үед Казахстаны нутагт байсан усунь нарын домог мөн болох нь тогтоогджээ. (46-н 39—102).

Одоогийн Монгол улсын нутгаар төвлөн тогтносон Хүннү улс МЭӨ 198 онд Хятадын Хан улстай байгуулсан гэрээгээр хоёр улс бие биенээ мөр зэрэгцэх улс гэж зөвшөөрөлцөж Цагаан хэрмээр хилээ тогтоожээ. Хүннү улс ийм хүчирхэг байсан учир Хүннү гэдэг нэр Европод хуин (гуин), Энэтхэгт хуна гэх мэтээр дэлгэрсэн юм. Хүннү улс МЭ 93 онд задархад хүннүгийн 100000 гаруй өрх (500000 гаруй хүн) сүмбэ нартай нийлэн өөрсдийгөө сүмбэ гэж нэрлэсэн учир Хүннүг залгамжлан мандсан Сүмбэ (II—IV зууны) бол (23) үнэн чанартаа Хүннү улс юм. Сүмбэ нар өөрийн хэлээр бичсэн номнуудтай байснаас гадна битэгчин (бичээчин) гэх эртний монгол хэлний үгтэй байсан (25-н 27—28) учир монголчуудын бичгийн соёлын уламжлал наана хэлэхэд 1700—1800 жилийн тэртээгээс эхэлнэ. Их Нирун улс (330 орчим 555)-ын хаан угсааныхны овгийг монгол, үндсэн хүн амыг нь хятад зэрэг бусад оронд нирун (нуруун), татар гэж хоёр янзаар нэрлэж байсан учир V—XIV зууны үед Ази, Европод монголчуудыг гол төлөв татар, заримдаа татар-монгол, монгол-татар (24-н 104—195, 25-н 39—42) гэж нэрлэдэг байв. Их Нирун улс бурхны шашны судар авидарма, санкхья гүн ухааныг тайлж чаддаг Дармаприя ламыг 489 оноос өм-

но төрийн багшаар томиж байсан (24-н 128—154, 25-н 54—55) учир монголчуудын дунд бурхны шашин буюу буддизм наана хэлэхэд 1500 гаруй жилийн уламжлалтай байна. Дээр дурьдсанас үзэхэд Хүншү, Сүмбэ, Их Нирун улсын үед монгол улсын түүхэн хөгжлийн вектор Орхон голын хөндийд төвлөрсөн монгол улс 760 жилийн турш мандаж байжээ.

Их улсын Амгай хаан төрийн ноён нуруугүй болчимгүй бодлого явуулсны уршгаар Алтайн цаана байсан түрэгчүүд Нирун улсыг 555 онд довтолон бутцохиж, Түрэг улсыг байгуулсан юм. Ингээд одоогийн Монгол улсын нутгийн баруун, төв хэсэгт Түрэг (555—745), Уйгур улс (745—840) 285 жил тогтнож байв. Их Нирун улсын үндсэн хүн ам түрэгчүүдэд хөөгдөн үндсэндээ одоогийн Хэнтий, Дорнод Сүхбаатар аймаг, мөн зэргэлдээ нутагт 555 оноос 30 татар (39-н 21, 29, 36), Татар улс (38-н 139—147), 1084 оноос Монгол улс, Хамаг Монгол улс гэх мэтээр нэрлэгдэн 651 жил жил оршин тогтнохдоо аажмаар хүчирхэгжин алдсан нутгаа эргүүлэн авсаар 1206 онд Их монгол улс байгуулан дэлхийн түүхийн тавцан дээр дахин мандаг гарсан юм. Дашрамд дурьдахад Хамаг Монгол улсын хаан зүрчидийн Алтан улсын довтолгооныг бутцохиж, 1147 онд Алтан улстай гэрээ байгуулан үхэр хонь 250000, торго 300000 толгой, хөвөн бараа, 300000 лаггийн алба авах болоод, улсаа Их Монгол улс гэж нэрлэж байжээ.

Их Монгол Улс (1206—1260) 54-хөн жил (31) оршин тогтносны гол шалтгаан бол Чингис 1203 онд Хэрэйдийн Ханлиг улсыг мөхөөн Ван хан, түүний дүү Жахамба (Жахамба) зэрэг хүнийг алуулаад Жахамбын охин, өшөөтөн дайсан Сорхохтани бэгийг олзлон авчирч голомтын хүү Тулуйн хатан болгосон явдал юм. Тулуйн удмынхан хаан ширээг Өгөөдэйн удмаас цус урсган булаан авсан (26-н 50—54), мөн Тулуйн хүү Хубилайг Чингисийн алтан ургийн бус хүмүүжлээр хүмүүжүүлсэн нь Сорхохтани хатны явуулга мөн нь мэдээж. Хубилайн (1215—1294) өрлөг эх нь найманы татвар эм Сарук, худам бичгийн багш нь уйгарын Толочу байжээ. Хубилайг 17 настай байхад нь 1232 онд эцэг Тулуй нь нас баржээ. Хубилайн эх Сорхохтани бэги 1236 онд одоогийн Хэбэй мужийн Чжэньдинд эзэмшил нутаг авч Хубилай өөрөө мөн онд одоогийн Хэбэй мужийн Синчжоуд түмэн хятад өрхтэй эзэмшил нутагтай болж хятад ноёд тавин захирч байхад нь бурхны шашны хятад лам Хуй Юнь (1202—1257) түүнийг Хятадын бурхны шашинтай танилцуулж хүүд нь Чжэньцзинь (шижир алт) гэх хятад нэр өгсөн нь персээр сунжираад Жингим болсон. Хубилай 1240 оноос Чжао Пи (1220—1276), Доу Мо (1196—1280) гэх хоёр хятад түшмэлээс кунзийн ёсны мэдлэг олж авчээ (266-н 81). Их Монгол Улсын хаан Мөнх хятадын Сун улсыг байлдан дагуулахаар явж байгаад Сычуаньд 1258 онд өвчнөөр хальснаас хойш «Хубилай хятад бичгийн түшмэл Хао Цзиний саналаар монголын хуралдааны хаан сонгох ёс журмыг эвдэж 1260 онд өөрөө хаан болжээ» гэж орчин үеийн хятадын эрдэмтэн Шан Юэ бичжээ (30-н 35). Хубилай хаан ширээ булаан авсаар Монгол улсын нийслэлийг харь орны Бээжинд шилжүүлэн 1271 онд хятад түшмэл Лю Бинчжун (1216—1274), Ван Пань (1202—1293) нарын зөвлөснөөр Их Монгол Улс гэдэг нэ-

рийг өөрчлөн Юан гэдэг хятад нэртэй улс (1260—1368) байгуулан монголын төр ёсны уламжлалыг завхруулсан юм. (26-н 83, 88—91).

Мөнхийн хаан ширээг орлон үлдээд, их хуралдайгаар 1260 онд Их Монгол Улсын хаанаар өргөмжлөгдсөн «Ариг-бөх төр улсынхаа уламжлал ёс журмыг үл хайхран өөрийн эрх ашгаас урвасан ахынхаа эсрэг арга буюу зэвсэгт тэмцэл хийхэд хүрсэн ажээ» гэж Юан гүрний түүхийг олон жил тусгайлан судалсан Ч. Далай (30-н 33) бичжээ. «Хубилай хятадын талыг барьсан хүн байсан учраас Монгол орноо хүндэтгэн үзэгч бүлгээс Хубилайтай тэмцэл хийх нь зүй ёсны хэрэг байв» гэж (30-н 35) Японы эрдэмтэн Ивамура, Кацифузи, нар бичсэн юм. Хубилай ингэж 1260—1307 он хүртэл 47 жил үргэлжилсэн иргэний дайн өдөөн, Монгол орныг сүйрүүлжээ. (26-н 84—87). Хубилай Монгол улсын түүхэн хөгжлийн векторыг монголын төр ёсны өлгий нутгаас зайлуулан монголын түүхэн хөгжлийг олон зуун жилийн доройтлын замд оруулсан юм. Юан гүрний үед (1260—1368) монголын төр ёсноос гадна монголын соёлын уламжлал гэж зарим талаар хятадчиллагдаж байсан талаар ердөө хоёрхон жишээ дурьдая. Монголчууд XIII зууны Монголын нууц товчоо зэргээс үзэхэд жилийн саруудыг хувь, хураг гэх мэтээр тус тус нэрлэдэг байсан. (26-н 63) бол XVII зууны эцсээр зохиогдсон Лувсанданзаны Алтан товч зохиолд хятад хэлийг дууриан 4 сар гэх мэтээр нэрлэсэн байв. Саган сэцэн 1663 онд зохиосон Эрдэнийн товч зохиолдоо 12 жилийн эшийн 10 өнгийг заасан хөх, хөхөгчин гэх монгол үгний оронд и, бин, дин мэтийн хятад үгс хэрэглэн хятадчилжээ (19-н 30—35), Монгол угсаатан соёлыг талаар энэ мэтээр хятадчиллагдаж байснаар барахгүй, Юан гүрний үед эртний табгач, кидан нарын адил хятадад уусан мөхөх юулд оржээ. Юан гүрэн 1368 онд Хятадад мөхөж монголын төв өлгий нутагтаа ирснээр дээрх аюулаас аврагджээ.

Манжийн хаад Монгол улсыг эзлэхийн тул өөрсдийн гэр хөл болсон Далай ламаар дамжуулан, Монголын төр ёс, шашны уламжлалд байхгүй богд гэдэг шашны толгойлогчийн цол бий болгож, түвдийн шарын шашныг тэр хэвээр нь Монголд дэлгэрүүлэн улс төр, үзэл суртлын зэвсгээ болгоод, Юангаас хойш 323 жил оршин тогтносон Монгол улсыг 1691 онд Манж Чин (1644—1912) улсад дагаар оруулан, Монголын түүхэн хөгжлийн векторыг хятадад шилжүүлэн Монголыг 220 жил колоничлон дарласан юм. Манжийн колоничлолын нэг гол уршиг бол хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчид монголын ард түмнийг яс чөмгөнд нь хүртэл мөлжин хоосруулж Монголын эдийн засагт ноёрхлоо тогтоосон явдал (3-4) мөн.

Манжийн колоничлолын зэвсэг болсон түвдийн шарын шашин тэр хэвээрээ Монголд дэлгэрэхдээ монголын соёл, ёс суртахууны уламжлалыг гажуудуулан доройтуулснаас гадна Монголчуудын гэр бүлийн байдлыг ихээр завхруулан монголчуудыг биологийн хувьд мөхөх аюулд оруулсан юм. Түвдийн шарын шашин монгол хэлийг шашны хүрээнээс шахан зайлуулсан юм. Үхсэн хүний цогцсыг түвдүүд огтчин махчин шувуунд өгдөг ёсыг арай аятай болгон Монголд үхсэн хүнээ хээр ил оршуулдаг болгосон. Мөн төвдийг дууриан хундагатай архинд хиртэй хуруугаа дүрэн сэржим өргөх зэрэг монголын ёс заншил гажуудсан жишээ олныг дурдаж болно.

Түшээт хан аймгийн Вангийн хүрээнд эхнэрээ сард 30—35 төгрөгөөр хөлсүүлэн амьдардаг хүн байсан тухай Кооль-Эстивенд 1915 онд бичсэн (35-н 6) юм. Улаанбаатарт лам нар, хятад худалдаачдын 70—80 хувь нь түр зуурын эхнэртэй байдаг, монголын залуу хүүхнүүдийн тэн хагас нь хятад худалдаачидтай нөхцөн амь зуудаг... Өнгөрсөн жил Коминтерний хийсэн судалгаагаар 300 өрхөөс ердөө ганц хүн үнэхээр өнгөний өвчингүй байв» гэж Шаньси мужаас Монголд ирж 10 гаруй жил суусан нэг хятад худалдаачин Гоминданы төлөөлөгчдөд 1927 оны эхээр ярьсаныг Ма Хэтянь 1932 онд нийтлэгдсэн номондоо бичжээ (45-н 128). Ардын хувьсгалын эхний үеийн бүртгэлд бутач хүн олон байсан нь дээр дурьдсаны нэг нотолгоо мөн нь мэдээж. БНХАУ-ын эрдэмтдийн судалснаар XVI зууны сүүлчээр монголчууд 1090000 байснаа XVIII зууны эцсээр 60000 хүнээр, дараахь 100 гаруй жилийн дотор 261000 хүнээр буюу 23.9 хувиар хорогдон 829000 болсон байна. (11-н 71). Эрдэмтэн Кооль-Эстивенд Түшээт хан аймгийн Ахай гүн, Намсрай ван, Ханд чин вангийн хошууны хүн амыг нарийвчлан судлаад монголчууд биологийн талаар мөхөх аюулд орсон тухай 1915 онд бичжээ (35-н 12). Хүн ам зүйч, эмч Гүр 1921 оны өмнөх монголчууд мөхөх аюулд орсныг нотолсон юм (12-н 138—134). 1918 оны тооллогоор Монголын хүн ам 648000 байсны дотор 100000 хятад цагаачид байсан, тэд нэмж ирсээр байсан учир хятадчилагдах бодитой аюул бас нүүрэлсэн байна.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл ялсны үр дүнд 1911 онд Монгол улс байгуулагдан (13, 18) монголын сэргэн мандалтын эхэн тавигдаж эхэлсэн боловч Монгол улсын төрийн зүтгэлтнүүд нийт монгол угсаатныг нэгтгэн нэгэнт үеэ өнгөрүүлсэн Их Монгол Улсыг дахин байгуулах гэж мунхаглан зүтгэсээр байгаад Хятад, Орос хоёрыг хуйвалдуулан, Монгол улсаа 1915 оны 5-р сард устгуулж Хятадын харъяаны автономит улс болгуулсан юм. Хятадын цэрэг Монголд цөмрөн орж 1919 онд Автономит Монголыг устган хятад цэргийн харгис дарангуйлал тогтоожээ. Ингээд тусгаар тогтносон Монгол улс, биеэ даасан монгол үндэстэн дэлхийн түүхийн тавцангаас үүрд арилан үгүй болж болох дардан зам нээгджээ.

1921 оны Монгол Ардын хувьсгалын ялалтын үр дүнд малчин ардын язгуур эрх ашгийг хамгаалсан Ардын төр (20) тогтож, хар, шар феодал ангийн дарангуйлал устаж, ард түмний оюун санааг мунхруулагч хар тамхи болох түвдийн шарын шаны дангаар ноёрхсон ноёрхол эцэс болж, эрх чөлөөт, тусгаар тогтносон цэцэглэн хөгжсөөр байсан БНМАУ байгуулагдсан (9, 10) билээ.

1921—1990 оны үе бол Монгол Улс, Монголын ард түмний жинхэнэ сэргэн мандалт мөн нь дор дурдсан үгүйсгэхийн аргагүй түүхэн үнэнээр бүрэн нотлогдон байна. Үүнд:

1. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгийн 10 боть эмхтгэлийг (6, 16) үзэхэд БНМАУ 1961 онд НҮБ-ын гишүүн болж, 1990 оны байдлаар дэлхийн 107 улстай дипломат харилцаа, 12 улстай худалдааны харилцаа тогтоож, олон улсын засгийн газрын хоорондын 22 засгийн газрын бус 59 байгууллагын гишүүн болж, тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд дэлхийн түүхийн тавцан дээр XIII зууны Их Монгол Улсаас хойш анх удаа гарчээ.

2. «БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд «1921—1991)» статистикийн эмхтгэл (7), дэлхийн эдийн засгийн том бүтээлийг (47) нягтлахад БНМАУ 1990 оны байдлаар дэлхийн дунд зэргийн хөгжилтэй орны тоонд орсон байна.

3. «БНМАУ-ын соёлын түүх»-ийн 2 боть (8), БНМАУ-ын түүхийн нэгэн боть, 3 боть зохиолыг (9, 10) үзэхэд БНМАУ-д жинхэнэ соёлын хувьсгал ялж насанд хүрсэн бүх хүн бичигтэн болж, ардын боловсролын шинэ систем тогтож соёлын бүх төрлийн мэргэжлийн салбар, үндэсний мэргэжилтэн бий болсноос хоёр жишээ дурдвал, манжийн колоничлолын уршгаар нийгмийн амьдралын зарим салбараас шахагдсан Монгол хэл БНМАУ-ын дотор дангаар ноёрхож, орчин цагийн биеэ даасан утга зохиол бий болж, орчин үеийн монголын утга зохиолын хэл бүрэлдэн тогтсоныг орчин цагийн утга зохиолын түүх (28, 29) нотлон харуулж байна. Дүрслэх урлагийн мэргэжлийн байгууллага мэргэжилтэн бий болжээ (21).

4. БНМАУ-д орчин үеийн нийгэм, байгалийн шинжлэх ухааны гол салбар, дэлхийд нэрд гарсан эрдэмтэд, мэргэжилтэн нар бий болсныг БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн товч түүх (32) гэрчлэн харуулж байна.

5. БНМАУ-д орчин үеийн мэдээллийн бүх салбар, мэргэжлийн сэтгүүлчид (27) бий болжээ.

6. Биологийн хувьд мөхөх аюулд орсон 500000 гаруй монголчууд БНМАУ-д орчин үеийн анагаах ухааны бүх салбар, төрөл бүрийн өндөр мэргэжилтэй эмч нар бий болсныг (8-н 278—331, 281—314, 10-н 659—663) ачаар өсч, эрүүлжин 1990 оны байдлаар 2149000 хүнээс бүрдсэн орчин үеийн биеэ даасан монгол үндэстэн бүрэлдэн тогтжээ. (7-н 13) Энэ бүхэн бол Монгол улсын түүхэн хөгжлийн вектор өлгий нутагтаа маш таатай нөхцөл байдалд үйлчилсний бодит үр дүн мөн.

Нэг талаар дэлхийд колонийн систем ноёрхож байсан, нөгөө талаар Хятад улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган өөртөө нийлүүлэх стратегийн бодлогоо хэрэгжүүлэхийн тул улс төр-цэрэг эдийн засаг, соёл, үзэл суртал, хүн ам зүйн талаархи ажил явууллагаа ил, далдаар үйлдсээр байсны (11) зэрэгцээ Япон 1931—1945 онд Манжуурт цэргийн ноёрхлоо тогтооц БНМАУ-ын эсрэг тагнах, хорлон сүйтгэх, түрэмгийлэх ажиллагаа явуулсаар байсан (10-н 443—451) учир 1921—1945 онд БНМАУ Коминтерний «зааврыг дагах» үгүй. Зөвлөлт Холбоот Улстай найрсаг харилцаа бүх талын хамтын ажиллалгаа тогтоолгүй өөр замаар замласан бол тусгаар тогтносон БНМАУ байхгүй болох байсан нь дэлхий дахинд тодорхой билээ.

Энэ бол тухайн үед Коминтерн, ЗХУ-д түшиглэн, сөрөг векторууд, сөрөг хүчний параллелограммуудыг БНМАУ-ын түүхэн хөгжилд давамгайгаар үйлчлүүлэлгүй, эерэгүүдий нь үйлчлүүлж чадсаны үр дүн юм.

БНХАУ-ын удирдлага БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган БНХАУ-д нийлүүлэх явдлыг БНХАУ-ын төрийн стратегийн бодлого болгоод түүнийг хэрэгжүүлэхийн тул БНМАУ-ыг БНХАУ-д нийлүүлэх асуудлыг 1949, 1954 онд Зөвлөлтийн удирдлагад тавьсан БНМАУ-д «300 жилийн өрөө төлнө» гэдэг хуурамч үгээр халхлан БНМАУ-д 100000—200000 хятад ажилчин, 200000—300000 хятад тариачин оруулах,

Өмнөговь аймгийнхныг нүүлгэн оронд нь хятад хүмүүс оруулан суурьшуулах асуудлыг 1952, 1956, 1957 онд БНМАУ-ын удирдлагаар зөвшөөрүүлэх гэж зүтгэж байсан, чингээд энэ бүхэн нь бүтэхгүй болохоор шахалт үзүүлэх, сүрдүүлэх, хорлон бусниулах, түүх гуйвуулах (17, 42) зэрэг өргөн хүрээтэй элдэв явуулгыг БНМАУ-ын эсрэг 1980 хэдэн он хүртэл явуулсаар байсныг дэлхий дахин мэднэ. БНМАУ-ын удирдлага энэ үед ЗХУ, бусад социалист оронтой найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн өргөжүүлэх замаар БНМАУ-ын эсрэг хятад вектор, хятад хүчний параллелограммуудын үйлчилгээг саармагжуулан 1990 оны үеийн БНМАУ-ыг бий болгож чаджээ.

Гэтэл 1990 оноос хойш сөрөг вектор-сөрөг хүчний параллелограммууд үйлчилсээр байсны уршгаар Монгол улс нийгэм-улс төр, эдийн засаг, соёл, ахуй амьдрал, ёс суртахуун, хүн ам зүйн талаар өөрөөр хэлбэл нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан гүнзгий хямралд орж хөгжлийн хувьд олон жилээр хойш ухарчээ.

БНМАУ орчин үеийн зах зээлийн нээлттэй эдийн засгийн нөхцөл байдлыг маш овжин ашиглаж хятадын худалдаа үйлдвэрийн хүмүүсийг Монгол улсын тусгаар тогтнолын эсрэг өдөөн дайчилсан «Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл» номыг (41) 1993 онд Бээжинд 50000 хувь хэвлэж, Монгол улсын эсрэг хятад вектор-хятад хүчний параллелограммуудын түрэмгийлэл эхлээд байна. Гэтэл 1990 оноос хойш евразийн шинжтэй монголын соёлыг «дорно дахины соёл» гэх зохиомол томъёололд хамааруулаад манжийн колоничлолын үеийн төр, шашин, соёлын уламжлалыг Монгол улсын дотор сэргээн хятадын иргэншлийн нөлөөний (орбит) тойрог замд Монгол улсын түүхэн хөгжлийн векторыг аажмаар оруулах ажиллагааг Монгол улсад явуулсаар байна. Иймд өнөөдөр Монгол улсын түүхэн хөгжлийн чиглүүлэх эсрэг вектор, эсрэг хүчний параллелограммуудыг Монгол улсад үйлчлүүлэх нь тэргүүлэх зорилго болжээ. Үүний тул газар зүйн улс төр (гео-политика)-ийн үндсэн дээр Монгол улсын үндэсний эрх ашгийн концепцийг тодорхойлон, Монгол улсын төрийн стратегийн бодлогыг боловсруулж түүнийг уян тактикаар хэрэгжүүлж эхлэх нь зайлшгүй чухал байна.

Монгол улс бол дэлхийн цөөн хүнтэй, уудам нутагтай өвөрмөц орон билээ.

Орчин үеийн дэлхийн нэрт сэтгэгчийн нэг Олвин Тоффлер дэлхийн олон улсад олон арван сая хувиар нийтлэгдсэн «хүчний шилжилт» зохиолдоо ирээдүйд «хутагтын (шашны) хэнээрхэл» болж «үзэл суртлын үндсэн тэмцэл... ХХI зууны ардчилал, ХI зууны харанхуй үеийн хооронд болно» гэж (44-н 364—379) зөгнөн бичжээ. Япон дахь бурхны шашны «Аум Шинрикио» бүлэг Токиогийн метро дотор хорт хий тавин олон хүний амийг хөнөөсөн, хөнөөх гэж байгаа түгшүүртэй мэдээ нийтийн хэвлэлд гарсаар байна. Манжийн колоничлолын зэвсэг болсон түвдний шарын шашин төр хэлбэрээрээ Монгол улсад маш түргэн дэлгэрсээр байна. Монголын хоёрдугаар Богд Манжийн эсрэг Чингүнжавын бослогыг нэг удаа талархсан учир 1757 онд хорлогдон таалал төгсөхөд Халхын том лам, ноёд Халхын 7 хүүхдийг гуравдугаар Богдын хойт дүрд тодруулсан юм. Гэтэл Манжийн Тэнгэрийн тэтгэсэн оны

цолт хаан төрийн бодлогын ашиг сонирхлын үүднээс гуравдугаар Богдыг Түвдээс тодруулж (43-и 263—266) дараачийн 5 богдыг түвдээс тавьж Монголын шашныг толгойлуулсан. Наймдугаар богд Жавзундамба 1924 онд таалал төгсөхөд түүний дүрийг халхаас тодруулсан боловч ширээнд залаагүй. Гэтэл арваад жилийн дараа 1930 хэдэн онд 9-р Богдыг Түвдээс дахин тодруулсан нь Хятадын төрийн бодлоготой холбоотой нь мэдээж.

Дээр дурдсанаас үзэхэд Монгол улс төрийн стратегийн бодлогоо боловсруулахдаа XXI зууны хүчний шилжилтийг харгалзах ёстой нь мэдээж.

## НОМ ЗҮЙ

1. Ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ. 1961.
2. Ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ. 1969.
3. Ар Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлэл (1751—1911) Баримт бичгүүд. УБ. 1988.
4. Аюудайн Очир. Монгол-Хятадын худалдааны харилцаа (XIX—XX зууны эхэн). УБ. 1995.
5. Ж. Батсуурь. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгисөн нь «Дорно дахины судлалын асуудал», 1988. № 1 (18). 81—90-р тал.
6. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1921—1985. I—VIII боть. УБ. 1964—1988.
7. БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд (1921—1991). УБ. 1991 (монгол, англиар)
8. БНМАУ-ын соёлын түүх. 1921—1960. 1, 2-р боть, УБ. 1981, 1986.
9. БНМАУ-ын түүх. 3 боть. УБ. 1966—1969
10. БНМАУ-ын түүх. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. УБ. 1984 он.
11. «Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл» номын тухай шүүмж Зүүн хойт Ази судлал сэтгүүл, 1994 № 01, (4). УБ. 59—96-р тал.
12. Р. Гүр. Хүн амын эрүүл мэндэд хийсэн статистик судалгаа. УБ. 1967.
13. Н. Магсаржав. Монгол улсын шинэ түүх. УБ. 1994.
14. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920—1960. Нэг, хоёрдугаар дэвтэр. УБ. 1966, 1967.
15. Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд. Дэд дэвтэр. УБ. 1985.
16. Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921—1974. 1, 2-р боть. Улаанбаатар-Москва, 1976, 1981.
17. Монгол үндэстний товч түүх. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот, 1988 (худам бичгээр)
18. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгүүдийн эмхтгэл. (1900—1914). УБ. 1982.
19. Саган Сэцэн. Эрдэнийн товч Ц. Насанбалжир хэвлэлд бэлтгэв. УБ. 1961. (худам бичгээр)
20. М. Санждорж. Ардын төрийн түүх. УБ. 1974.
21. Л. Сономцэрэн, Л. Батчулуун. Монголын дүрслэх урлагийн түүх. УБ. 1989.

22. Г. Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ, 1980.
23. Г. Сүхбаатар. Сяньби. УБ, 1971.
24. Г. Сүхбаатар. Монгол-Нирун улс. УБ, 1992.
25. Г. Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ, 1992.
26. Г. Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр. УБ, 1992.
27. Үнэн. Улсын хэвлэлийн газар. УБ, 1990.
28. П. Хорлоо, С. Лувсанвандан, Ц. Мөнх, Д. Цэнд. Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх (1921 — 1965) УБ, 1968.
29. Монголын орчин үеийн уран зохиолын түүх. 1921 — 1960. 1, 2-р боть. УБ, 1985, 1989.
30. Чулууны Далай. Монголын түүх (1260 — 1388). УБ, 1992.
31. Чулууны Далай. Их Монгол Улс 1206 — 1260. ШУХ. «Эрдэм» компани, УБ, 1994.
32. Б. Ширэндэв. БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн товч түүх. УБ, 1980.
33. Древние культуры Монголии. Новосибирск. «Наука» 1985.
34. Актуальные проблемы современного монголоведения. УБ, 1987.
35. Иоханнес Кооль-Эстивенд. О. движении населения в Монголии-Вестник Азии. Книга III—IV. 1915. № 35—36. Харбин.
36. О. Исмагулов. Этническая география Казахстана (Серологические исследования), Алма-Ата, 1977.
38. Монголия к 750 летию «Сокровенного сказания». Издательская фирма. «Восточная литература». Москва, 1993.
39. С. Е. Малов. Памятники древнетюркской письменности Москва, Ленинград, 1951.
40. Ю. Г. Рычков, Ж. Батсуурь. «Монголы МНР и монголоидное на I селение Азии в свете географии» — «Вопросы Антропологии», выпуск. 78, 1987. сс, 44—68.
41. Вай мэngu дули нэйму (Гадаад монголын тусгаар тогтнолын нууц үгсэл) Жэньминь чжунго хэвлэлийн газар. Бээжин 1993 (50000 хувь).
42. Мэngu цзу цзяньши (Монгол үндэстний товч түүх). Хөх хот, 1985.
43. Altaic Religios Beliefs and Practices. Proceeding of the 33 rd Meeting of the Permanent International Altaistic Conference. Budapest. June 24—29, 1990. Budapest 1993.
44. Alvin Toffler. Powershift. Bantam Books. New York. 1991.
45. Chinese Agent in Mongolia by Ma Ho—T, ien Translated by John De Francis. Baltimore. The Johns Hopkins Press. 1949.
46. Kljastornyj and Livsic (Leningrad). The Sogdian Inscription of Bugut Reviced—Acta Orientalia. Tomus XXVI, Fasc I. Budapest. 1972. p. 69—102.
47. Stanley Fisher, Rudiger Dornbusch, Richard Schmaltencee. Economics. Second Edition. London. 1988.